

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>	
<p><i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i></p>	
<p><i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/</i></p>	<p>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр</p>
<p><i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i></p>	<p>Нэр: “ЛэндМН ББСБ” ХК  УБГД: 000166216  Үнэт цаасны код: MN0LEND05453  Утасны дугаар: 77222949, 77070101</p>
<p><i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i></p>	<p>“Монголын Хөрөнгийн Бирж” ХК</p>
<p><i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i></p>	<p>Санхүүгийн салбар – банк бус санхүүгийн салбар</p>
<p><i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i></p>	<p>800,000,000 ширхэг</p>
<p><i>Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i></p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i></p>	<p>Хагас жилийн тайланг бэлтгэсэн:  Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн Н.Мөнхцэцэг</p> <p>Хагас жилийн тайланг хянасан:  ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд</p>


1.	<i>Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ /Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>						
	<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав.					
	<i>Орлогын тайлан</i>						
	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	Өмчийн өөрчлөлтийн тайлан /тэрбум төгрөг/	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Бусад нөөц	Х.ашиг	Нийт эздийн өмч
		2022.12.31-ний өдрийн байдлаар	10.8	(2.3)		15.7	24.2
		Тайлан үеийн цэвэр ашиг				19.8	
		Ногдол ашиг				(1.3)	
		Халаасны хувьцаа					
		2023.12.31-ний өдрийн байдлаар	10.8	(2.3)		34.2	42.7
		Тайлан үеийн цэвэр ашиг				17.1	
		Ногдол ашиг				(5.9)	
		Халаасны хувьцаа					
		2024.06.30-ний өдрийн байдлаар	10.8	(2.3)		45.4	53.9

<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	<b>Мөнгөн гүйлгээний тайлан /гэрбум төгрөг/</b>	<b>2022Н</b>	<b>2023Н1</b>	<b>2024Н1</b>
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4.9)	(3.8)	1.4
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(0.3)	(0.2)	(0.3)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2.3	5.6	9.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт	(2.9)	1.6	10.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4.9	5.9	8.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2.0	7.5	18.9
2.	<i>Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>  <i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>			
	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хавсаргав.			
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>			


3.1


Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

2024 оны эхний хагас жилийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал:



2024 оны эхний хагас жилд нийт харилцагч нартаа 465.8 тэрбум төгрөгийн дүнтэй 1,056.3 мянган зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна.





Түүнчлэн 2024 оны эхний хагас жилийн зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2023 оны хагас жилтэй харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 7.3%, олгосон зээлийн тоо 3.8%, зээлийн багц 107.5%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

#### Зээлийн багцын чанарын үзүүлэлт



2024 оны эхний хагас жилийн байдлаар зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 1.1%-иар буурч 3.6% хүрсэн ба зээлийн эрсдэлийн сангийн нөөц 7.1 тэрбум төгрөг буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 93.2% хүргэж ажиллалаа.

3.2	<p><i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i></p>	<p><b>Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд</b></p> <p>“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9)-н дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2024 оны эхний хагас жилийн байдлаар 4.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9) стандартын дагуу 7.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 93.2%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилладаг болно. Тухайлбал, Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 10%-иас доошгүй байх шаардлагатайгаас 22.7%, Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 20%-иас доошгүй байх шаардлагатайгаас 27.6%, төлбөр түргэх гүйцэтгэх чадварын харьцаа 8%-иас дээш байх шаардлагатайгаас 16.8% тус тус байна.</p>
3.3	<p><i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• “ЛэндМН ББСБ” ХК нь 2024 оны I улиралд жижиг, дунд бизнес эрхлэгч нарт санхүүжилт шийдэхэд тулгардаг гол асуудлууд болох барьцаа хөрөнгө, цаг хугацаа, ажиллагааг хэмнэсэн 100% дижитал бизнесийн зээлийн бүтээгдэхүүнээ Монголд анх удаа нэвтрүүлээ. Жижиг, дунд бизнес эрхлэгч нар маань дийлэнх нь эмэгтэйчүүд байдагтай уялдуулан бид “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр” болон Худалдаа эрхлэгч нартаа зориулан ”Бизнесээ хөрөнгө оруулъя” уриатайгаар 2 удаагийн идэвхжүүлэлтийг хийсэн. Хэдийгээр бизнесийн зээлийн бүтээгдэхүүн маань зах зээлд нэвтрээд 3 сарын богино хугацаа өнгөрсөн боловч LendMN аппликейшнээр 5,000 гаруй Жижиг, дунд бизнес эрхлэгчид бизнесийн зээлийн тооцооллоо хэдийнээ хийлгэж, нийт 56.2 тэрбум төгрөгийн зээлийг 10,667 удаагийн давтамжтайгаар олгоод байна. Түүнчлэн 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт зээлийн багц 180.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс 30.5 тэрбум төгрөг нь бизнесийн зээлийн багцаас бүрдэж байна. Харилцагчдын 65% эмэгтэй, 22% нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчид байна. ЛэндМН-ийн зүгээс цаашид тэргүүн ээлжид Худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй Жижиг, дунд бизнес эрхлэгч нартаа хэрэгцээт үедээ LendMN аппликейшн дээрээс зээлийн эрхээ шалгаж, санхүүжилтээ шийдэх боломжийг нээлттэй болгож байна</li> <li>• “ЛэндМН ББСБ” ХК нь 2022 онд олон нийтэд нээлттэй гаргасан “Лэнд Бонд Транч II”-ын эргэн төлөлтийг хүүгийн хамт 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр, улирал тутам өгөөж төлөх нөхцөлтэй 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр арилжаалсан "Лэнд Бонд"-ын өгөөжийг</li> </ul>

		<p>хуваарийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр үнэт цаас эзэмшигчдийн дансанд тус тус байршууллаа.</p> <ul style="list-style-type: none"> <li>“ЛэндМН ББСБ” ХК нь 2024 онд гаргасан хаалттай өрийн хэрэгсэл болох “Лэнд Бонд Транч I”-ийн эхний хүүгийн төлөлтийг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр, “Лэнд Бонд Транч II”-н эхний хүүгийн төлөлтийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, “Лэнд Бонд Транч III”-ын эхний хүүгийн төлөлтийг 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр үнэт цаас эзэмшигчдийн дансанд тус тус байршуулан ажиллалаа.</li> </ul>								
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй болно.								
4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>									
	<p>4.1 Их хэмжээний хэлцэл Тайлант хугацааны турш их хэмжээний хэлцэл хийгээгүй.</p> <p>4.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс холбоотой талаас санхүүжилт хүлээн авах, баталгаа гаргуулахтай холбоотой нийт 1 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн ТУЗ-өөс</p> <p>Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна. Үүнд:</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Хэлцлийн нөгөө тал</th> <th>Зөвшөөрөл олгосон огноо</th> <th>Хэлцэл хийсэн зорилго</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>“АНД Системс” ХХК (Толгой компани)</td> <td>2024.03.07</td> <td>“АНД Системс” ХХК-д үзүүлж буй үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэн, цаашдын хамтын ажиллагаа нь хамтын өсөлт хөгжилд эерэг нөлөөтэй болохыг харгалзан үзэж тус компанитай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 10,000,000,000 (Арван тэрбум) хүртэл төгрөгийн зээлийн шугамыг 20,000,000,000 (Хорин тэрбум) хүртэл төгрөг болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэв.</td> </tr> </tbody> </table>		№	Хэлцлийн нөгөө тал	Зөвшөөрөл олгосон огноо	Хэлцэл хийсэн зорилго	1	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2024.03.07	“АНД Системс” ХХК-д үзүүлж буй үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэн, цаашдын хамтын ажиллагаа нь хамтын өсөлт хөгжилд эерэг нөлөөтэй болохыг харгалзан үзэж тус компанитай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 10,000,000,000 (Арван тэрбум) хүртэл төгрөгийн зээлийн шугамыг 20,000,000,000 (Хорин тэрбум) хүртэл төгрөг болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэв.
№	Хэлцлийн нөгөө тал	Зөвшөөрөл олгосон огноо	Хэлцэл хийсэн зорилго							
1	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2024.03.07	“АНД Системс” ХХК-д үзүүлж буй үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэн, цаашдын хамтын ажиллагаа нь хамтын өсөлт хөгжилд эерэг нөлөөтэй болохыг харгалзан үзэж тус компанитай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 10,000,000,000 (Арван тэрбум) хүртэл төгрөгийн зээлийн шугамыг 20,000,000,000 (Хорин тэрбум) хүртэл төгрөг болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэв.							

5.	<p><i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i></p>
	<p>“ЛэндМН ББСБ” ХК нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.</p>
6.	<p><i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i></p>
	<p>“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН”) нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор байна.</p> <p>ЛэндМН-ийн зүгээс Хөрөнгө оруулагч, Хувьцаа эзэмшигч болон Харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал, хагас жил, жилийн эцсийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримтлан ажиллаж, тухай бүр тайлан бэлтгэж олон нийтэд хүргээд байна.</p> <p>Тодруулбал, 2023 оны жилийн эцсийн тайланг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр, 2024 оны I улирлын тайланг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгоход анхаарч ажилласан болно.</p> <p>2024 оны эхний хагас жилийн хугацаанд ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.</p> <p><b>ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ</b></p> <p>“ЛэндМН ББСБ” ХК нь 7 дахь жилдээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тасалдуулахгүй амжилттай зохион байгуулан ажиллалаа.</p> <p>Компанийн зүгээс Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу Компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Бэст Вэстэрн Примьер Туушин зочид буудал (Best Western Premier Tuushin Hotel)”-ын 5 давхарт байрлах “Соёмбо” танхимд зохион байгуулсан ба саналын эрх бүхий хувьцааны 81.7% буюу 603,983,333 (Зургаан зуун гурван сая есөн зуун наян гурван мянга гурван зуун гучин гурав) ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;</li> <li>- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;</li> </ul>



- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчид хуралдаа идэвхтэй оролцож, ЛэндМН-ийн цаашдын хөгжил болоод үйл ажиллагааны талаар Удирдлагын багаас мэдээлэл авч, мөн өөрийн санал, хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд ЛэндМН-ийн ирээдүйд итгэж буйгаа цохон тэмдэглэж байв. ЛэндМН-ийн зүгээс өмнөх жилүүдэд ашигласан цахим санал хураалтын системийг энэ удаагийн ХЭЭХ-д ашигласан нь санал хураалтын дүнг түргэн шуурхай гаргах боломжийг бүрдүүлж, хурлын үр дүнтэй Хувьцаа эзэмшигчид богино хугацаанд танилцах боломжийг олгосноороо онцлог байлаа.

### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ЦААШИД “ТУЗ”), ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ТУЗ нь ЛэндМН-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд ЛэндМН-ийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх захиралд компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 3 гишүүнийг сонгосон. ТУЗ-ийн ердийн 6 гишүүнээр Монгол Улсын иргэн О.Болдбаатар, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ, Ц.Одмаа, С.Энх-Амгалан, Япон Улсын иргэн Кацухико Мадано нар сонгогдсон бол ТУЗ-ийн хараат бус 3 гишүүнээр Монгол Улсын иргэн Ж.Жаргалсүрэн, С.Боргил, С.Нэргүй нар сонгогдсон болно. Ийнхүү ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 3 гишүүдийг сонгогдсоноор ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон бөгөөд ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргыг сонгож, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн болон ТУЗ-ийн 2024 оны ээлжит хурлын хуваарийг шинэчлэн баталсан байна.

ТУЗ нь 2024 оны эхний хагас жилд 2 удаа ээлжит хурал, 1 удаа ээлжит бус хурал, 4 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 26 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлээд байна.

ТУЗ-ийг эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1) Эрсдэлийн удирдлагын хороо, 2) Аудитын хороо, 3) Засаглал, нэр дэвшүүлэх хороо, 4) Цалин, урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

### **ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **Засаглал, нэр дэвшүүлэх хороо (цаашид “ЗНДХ”)**

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил; Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн, ТУЗ-ийн ердийн гишүүн О.Болдбаатар

ЗНДХ нь 2024 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгох асуудлыг Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай асуудлыг хэлэлцэж ажилласан байна.

**Цалин, урамшууллын хороо (цаашид “ЦУХ”)**

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй; Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил, ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Одмаа

ЦУХ нь 2024 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирлын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг баталж, цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоон, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулан ажилласан байна.

**Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид “ЭУХ”)**

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй; Гишүүд: ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Хос-Эрдэнэ, Ц.Ууганбаяр, Кацухико Мадоно, С.Энх-Амгалан

ЭУХ нь 2024 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**Аудитын хороо**

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн; Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил, ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Одмаа

Аудитын хороо нь 2024 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторыг томилохтой холбоотой дүгнэлт гаргах, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон ЛэндМН-ийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, ЛэндМН-ийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

**ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацааны мэдээлэл**

№	ТУЗ-ийн гишүүд	2024 оны эхний хагас жилийн ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	ЛэндМН-д хувьцаа эзэмшдэг эсэх
1	О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 7 дахь жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0077%
2	С.Энх-Амгалан	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 7 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
3	Кацухико Мадоно	100%	ХЭЭХ-аас сонгогдож, анхны жилдээ ажиллаж байна	Үгүй
4	С.Нэргүй	100%	ХЭЭХ-аас сонгогдож, анхны жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0012%

5	Б.Хос-Эрдэнэ	66.6%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
6	Ц.Ууганбаяр	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0028%
7	Ж.Жаргалсүрэн	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 7 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй
8	С.Боргил	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 7 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0010%
9	Ц.Одмаа	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй

ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, эсхүл “түдгэлзсэн” санал гаргах боломжтой.

ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд ЛэндМН-ийн үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулахад шаардлагатай, ач холбогдол бүхий шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар, дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ, ТӨРӨЛ БОЛОН БУСАД МЭДЭЭЛЭЛ

№	Шийдвэр гаргасан огноо	Ирц	Шийдвэр гаргасан хэлбэр	Баталсан тогтоолын тоо
1	2024 оны 01 дүгээр сарын 17	100%	Эчнээ санал хураалт	1
2	2024 оны 02 дугаар сарын 05	88.89%	Ээлжит хурал	7
3	2024 оны 02 дугаар сарын 19	100%	Эчнээ санал хураалт	1
4	2024 оны 03 дугаар сарын 04	100%	Эчнээ санал хураалт	2

5	2024 оны 03 дугаар сарын 07	88.89%	Ээлжит бус хурал	3
6	2024 оны 04 дүгээр сарын 24	88.89%	Ээлжит хурал	9
7	2024 оны 05 дугаар сарын 17	88.89%	Ээлжит санал хураалт	3

Удирдлага зохион байгуулалт	Санхүү	Эрх олгох	Үйл ажиллагаа	Бизнес стратеги
7	3	7	5	4

2024 оны эхний хагас жилийн байдлаар Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс холбоотой талаас санхүүжилт хүлээн авах, баталгаа гаргуулахтай холбоотой нийт 1 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна.

#### **НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ**

ЛэндМН-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу жил бүрийн цэвэр ашгаасаа Хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тараадаг билээ.

2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 24/03 тоот тогтоолоор ЛэндМН-ийн 2023 оны цэвэр ашгийн 29.9%-ийг буюу нэгж хувьцаанд 8 (Найман) төгрөг, нийт 5,914,413,464 (Таван тэрбум есөн зуун арван дөрвөн сая дөрвөн зуун арван гурван мянга дөрвөн зуун жаран дөрвөн) төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд ЛэндМН-ийн зүгээс ногдол ашгийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд байршуулж ажиллалаа.

7. *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

#### **“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ**

ЛэндМН нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөж, хэрэгжүүлэн ажилласан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны нэгдсэн үнэлгээний хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах үзүүлэлтэй байна.

№	Үндсэн зарчим	Авбал зохих нийт оноо	Авсан оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.33%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5	83.33%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>68</b>	<b>94.44%</b>

“ЛэндМН ББСБ” ХК нь “Компанийн засаглалын кодекс”, түүний зарчмуудыг 94,44%-тай хэрэгжүүлэн ажиллаж, компанийн засаглал болон соёлыг сайжруулан бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байна.

2024 оны үлдсэн хагаст “ЛэндМН ББСБ” ХК нь өөрийн холбогдох баримт бичгүүдийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн шинэчлэх, зохицуулалтуудыг Компанийн засаглалын кодекс”-тэй нийцүүлэхэд анхаарч ажиллах замаар өөрийн үнэлгээг тогтмол сайжруулахад анхаарах болно.

#### **БУСАД ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ**

2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах тайлан, мэдээллүүдийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хугацаанд илгээж, олон нийтэд мэдээлсэн байна. Үүнд:

- 2023 оны жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлан;
- 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2024 оны I улирлын үйл ажиллагааны тайлан;
- 2024 оны хагас жилд ТУЗ-өөс гарсан тогтоолууд;

- 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр, тэмдэглэл холбогдох баримт бичгүүд;
- Компанийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүд.

Түүнчлэн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Компанийн сошиал сувгууд болон харилцагчийн үйлчилгээний төвийн 77070101 тоот утсаар харилцагч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын санал, хүсэлт, асуултад тухай бүх хариу өгөн ажиллаж, мэдээлэл солилцон ажилласан байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Ууганбаяр

Албан тушаал: “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: 

  
lendmn  
(Тамга/тэмдэг)  
УЛААНБААТАР ХОТ  
5039754 ф. 1118267206

Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Оюунболд

Албан тушаал: “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг: 

Огноо: 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр

Байгууллагын нэр: ЛЭНДМН  
 Регистр: 5039754  
**САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл 2023/12/31	Эцсийн үлдэгдэл 2024/6/30
	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>1</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>7,885,968</b>	<b>18,935,378</b>
1.1	Бэлэн мөнгө	295	-
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	4,829,853	8,690,481
1.3	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	3,055,820	10,244,897
<b>2</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ / ЦЭВРЭЭР/</b>	-	<b>1,004,660</b>
2.1	Засгийн газрын үнэт цаас	-	-
2.2	Арилжааны үнэт цаас	-	-
2.3	Богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас	80,000	1,004,660
2.4	(Хөрөнгө оруулалтын үнэт цаасны эрсдэлийн сан)	-	-
2.5			
<b>3</b>	<b>ЗЭЭЛ /Цэврээр/</b>	<b>119,724,136</b>	<b>172,973,858</b>
3.1	Нийт зээл	125,391,058	180,080,103
3.1.1	Хэвийн зээл	116,268,031	169,685,471
3.1.2	Хугацаа хэтэрсэн зээл	3,961,259	3,825,940
3.1.3	Чанаргүй зээл	5,161,768	6,568,692
3.1.3.1	Хэвийн бус зээл	1,827,118	2,221,325
3.1.3.2	Эргэлзээтэй зээл	1,730,422	2,013,791
3.1.3.3	Муу зээл	1,604,228	2,333,575
3.1.4	(Зээлийн эрсдэлийн сан)	5,666,922	7,106,245
<b>4</b>	<b>САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ТООЦООНЫ АВЛАГА /ЦЭВРЭЭР/</b>	-	-
4.1	<b>Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага / төгрөгийн/</b>	-	-
4.1.1	Хэвийн санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.1.2	Хугацаа хэтэрсэн санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.1.3	Чанаргүй санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.1.3.1	Хэвийн бус санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.1.3.2	Эргэлзээтэй санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.1.3.3	Муу санхүүгийн түрээс тооцооны авлага	-	-
4.2	<b>Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага / валютаар/</b>	-	-
4.2.1	Хэвийн санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.2.2	Хугацаа хэтэрсэн санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.2.3	Чанаргүй санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.2.3.1	Хэвийн бус санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-
4.2.3.2	Эргэлзээтэй санхүүгийн түрээс тооцооны авлага	-	-
4.2.3.3	Муу санхүүгийн түрээс тооцооны авлага	-	-
4.2.4	Санхүүгийн түрээсийн эрсдэлийн сан	-	-
<b>5</b>	<b>ФАКТОРИНГИЙН ТООЦООНЫ АВЛАГА /ЦЭВРЭЭР/</b>	-	-
5.1	факторингийн тооцооны нийт авлага / төгөргөөр/	-	-
5.1.1	Хугацаандаа байгаа факторингийн тооцооны авлага	-	-
5.1.2	Хугацаа хэтэрсэн факторингийн тооцооны авлага	-	-
5.1.3	Чанаргүй факторингийн тооцооны авлага	-	-
5.1.3.1	Хэвийн бус факторингийн тооцооны авлага	-	-
5.1.3.2	Эргэлзээтэй факторингийн тооцооны авлага	-	-
5.1.3.3	Муу факторингийн тооцооны авлага	-	-
5.2	Факторингийн тооцооны нийт авлага/ валютаар/	-	-
5.2.1	Хугацаандаа байгаа факторингийн тооцооны авлага	-	-
5.2.2	Хугацаа хэтэрсэн факторингийн тооцооны авлага	-	-
5.2.3	Чанаргүй факторингийн тооцооны авлага	-	-
5.2.3.1	Хэвийн бус факторингийн тооцооны авлага	-	-

5.2.3.2	Эргэлзээтэй факторингийн тооцооны авлага	-	-
5.2.3.3	Муу факторингийн тооцооны авлага	-	-
5.3	(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	-	-
6	САНХҮҮГИЙН ДЕРИВАТИВЫН АВЛАГА	-	-
7	<b>7. БУСАД АВЛАГА</b>	<b>4,164,827</b>	<b>6,407,177</b>
7.1	<b>Бусад авлага</b>	426,590	469,833
7.2	Найдваргүй авлагын нөөц	-	-
7.3	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,738,238	5,937,344
7.3.1	Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	3,738,238	5,937,344
7.3.2	Хуримтлуулж тооцсон санхүүгийн түрээсийн хүүгийн авлага	-	-
7.3.3	Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага	-	-
7.3.4	Хуримтлуулж тооцсон факторингийн хүүгийн авлага	-	-
7.4	Салбар хоорондын тооцооны авлага	-	-
8	<b>БУСАД ХӨРӨНГӨ</b>	<b>86,668</b>	<b>111,285</b>
8.1	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	55,975	111,285
8.2	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	15,080	-
8.2.1	Хэвийн өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	15,080	-
8.2.2	Хугацаа хэтэрсэн өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	-	-
8.2.3	Чанаргүй өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	-	-
8.2.3.1	Хэвийн бус өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	-	-
8.2.3.2	Эргэлзээтэй өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	-	-
8.2.3.3	Муу өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	-	-
8.3	(Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн сан)	-	-
8.4	Материал, үнэ бүхий зүйлс	15,613	9,959
8.5	Бусад	-	-
9	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН</b>	<b>131,861,599</b>	<b>199,432,358</b>
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
10	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,251,811</b>	<b>1,466,468</b>
10.1	Барилга байгууламж	1,154,948	1,590,961
10.2	Хуримтлагдсан элэгдэл / барилга байгууламж/	203,659	488,596
10.3	Эд хогшил	104,755	133,533
10.4	Хуримтлагдсан элэгдэл / эд хогшил/	42,340	48,550
10.5	Техник хэрэгсэл	595,438	684,291
10.6	Хуримтлагдсан элэгдэл /техник хэрэгсэл/	357,331	405,172
10.7	Дуусаагүй барилга	-	-
11	<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>355,542</b>	<b>332,975</b>
11.1	Биет бус хөрөнгө	610,819	456,094
11.2	Элэгдэл /биет бус хөрөнгө/	255,276	123,119
12	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,607,353</b>	<b>1,799,442</b>
13	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>133,468,951</b>	<b>201,231,801</b>
	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
14	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>28,225,441</b>	<b>46,244,251</b>
14.1	Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл	11,632,182	25,474,542
14.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээлийн хугацаа хэтрэлт	-	-
14.3	Өрийн бичгээрх өглөг	16,593,259	20,769,709
14.4	Санхүүгийн деривативын өглөг	-	-
14.5	Төслийн зээлийн богино хугацаат санхүүжилт	-	-
15	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>35,889,390</b>	<b>50,622,621</b>
15.1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	35,661,746	50,403,193
15.2	Факторингийн үйлчилгээний өглөг	-	-
15.3	Мөнгөн гуйвуулгын өглөг	227,644	219,428
15.4	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	-	-
15.5	Төлбөрийн болон зээлийн картын үйлчилгээтэй холбоотой өг	-	-
16	<b>БУСАД ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,780,181</b>	<b>18,186,385</b>
16.1	<b>Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг</b>	<b>1,474,622</b>	<b>3,788,580</b>
16.1.1	Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг	446,420	2,277,687
16.1.2	Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн өглөг	263,808	264,179



16.1.3	Хуримтлуулж тооцсон бусад хүүгийн өглөг	764,394	1,246,714
16.2	<b>Бусад өглөг</b>	<b>8,305,559</b>	<b>14,397,805</b>
16.2.1	Салбар хоорондын тооцооны өглөг	-	-
16.2.2	Ногдол ашгийн өглөг	-	166,083
16.2.3	Цалингийн өглөг	309,972	246,389
16.2.4	ЭМД, НДШ-ийн өглөг	38,505	30,422
16.2.5	ХАОАТ-ын өглөг	208,607	151,673
16.2.6	Орлогын албан татварын өглөг	3,807,327	5,066,138
16.2.7	Бусад	3,941,149	8,737,100
17	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>73,895,012</b>	<b>115,053,257</b>
	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
18.1	Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	16,842,000	32,232,101
18.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээлийн хугацаа хэтрэлт	-	-
18.3	Төслийн зээлийн урт хугацаат санхүүжилт	-	-
18	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>16,842,000</b>	<b>32,232,101</b>
19	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>90,737,012</b>	<b>147,285,358</b>
	<b>В.ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		
20.1	Энгийн хувьцаа	8,000,000	8,000,000
20.2	Давуу эрхтэй хувьцаа	-	-
20.3	Халаасны хувьцаа	2,337,547	2,337,547
20	<b>ХУВЬЦААТ КАПИТАЛЫН ДҮН</b>	<b>5,662,453</b>	<b>5,662,453</b>
21	<b>БУСАД ӨМЧ</b>	<b>37,069,486</b>	<b>48,283,989</b>
21.1	Нэмж төлөгдсөн капитал	2,756,859	2,756,859
21.2	Хандивын капитал	57,348	57,348
21.3	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
21.4	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	-	-
21.5	<b>Хуримтлагдсан ашиг/ алдагдал/</b>	<b>34,255,279</b>	<b>45,469,782</b>
21.5.1	Тайлант үеийн ашиг /алдагдал/	19,795,816	17,110,331
21.5.2	Өмнөх үеийн ашиг/ алдагдал/	14,459,463	28,359,451
21.6	Нөөцийн сан	-	-
21.7	Нийгмийн хөгжлийн сан	-	-
22	<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>42,731,939</b>	<b>53,946,442</b>
23	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>133,468,951</b>	<b>201,231,801</b>



Байгууллагын нэр: ЛЭНДМН

Регистр: 5039754

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ХҮҮГИЙН ОРЛОГО</b>	<b>38,906,176</b>	<b>34,410,844</b>
1.1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	38,522,784	34,084,672
1.2	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	366,825	326,962
1.3	Үнэт цаасны хүүгийн орлого	3,432	-
1.4	Хугацаандаа байгаа санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	-	-
1.5	Хугацаа хэтэрсэн санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	-	-
1.6	Хугацаандаа байгаа факторингийн үйлчилгээний хүүгийн орлого	-	-
1.7	Хугацаа хэтэрсэн Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого	-	-
1.8	Харилцах дансны хүүгийн орлого	2,070	6,028
1.9	Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	24,184	450
1.10	Хүүгийн орлогын буцаалт	- 13,118	- 7,268
<b>2</b>	<b>ХҮҮГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,280,319</b>	<b>5,067,973</b>
2.1	Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	447,300	598,588
2.2	Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	3,071,759	3,034,046
2.3	Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал	-	-
2.4	Өрийн бичгийн хүүгийн зардал	2,761,259	1,435,338
2.5	Хүүгийн зардлын буцаалт /сөрөг утгатай/	-	-
<b>3</b>	<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО (1-2)</b>	<b>32,625,858</b>	<b>29,342,872</b>
<b>4</b>	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО (4.1+4.2+4.3)</b>	<b>10,793,259</b>	<b>5,171,285</b>
<b>4.1</b>	<b>Арилжааны цэвэр орлого (4.1.1+4.1.2)</b>	<b>-</b>	<b>-</b>
4.1.1	Гадаад валютын арилжааны орлого	-	-
4.1.2	Үнэт цаасны арилжааны орлого	-	-
<b>4.2</b>	<b>Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого (4.2.1+4.2.2)</b>	<b>227,219</b>	<b>226,848</b>
4.2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	227,219	226,848
4.2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	-	-
<b>4.3</b>	<b>Санхүүгийн үйлчилгээний шимтгэл (4.3.1+...+4.3.6)</b>	<b>10,566,040</b>	<b>4,944,438</b>
4.3.1	Санхүүгийн түрээсийн орлого	-	-
4.3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	-
4.3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	37,219	12,485
4.3.4	Картын үйлчилгээний орлого	-	-
4.3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	-	-
4.3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	10,399,988	4,871,375
4.3.7	Бусад үйлчилгээ	128,833	60,577

5	<b>ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ (5.1+5.2+5.3)</b>	<b>15,099,008</b>	<b>10,357,417</b>
5.1	<b>Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал (5.1.1+...+5.1.4)</b>	<b>84,107</b>	<b>73,082</b>
5.1.1	Гадаад валютын арилжааны зардал	-	-
5.1.2	Үнэт цаасны арилжааны зардал	-	-
5.1.3	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	84,107	73,082
5.1.4	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал	-	-
5.2	<b>Боловсон хүчний холбогдолтой зардал (5.2.1+...+5.2.10)</b>	<b>3,233,824</b>	<b>2,179,762</b>
5.2.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	2,323,021	1,619,133
5.2.2	Ажилтнуудад олгосон нэмэгдэл цалин, урамшуулал	538,142	278,628
5.2.3	Ажилтнуудад олгосон нөхөн олговор, хөнгөлөлт	-	-
5.2.4	Ажилтнуудад олгосон тэтгэмж, нийгмийн халамж	15,618	6,036
5.2.5	Гэрээгээр ажиллагсдын ажлын хөлс	-	-
5.2.6	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	352,507	236,007
5.2.7	Албан томилолт	4,535	39,959
5.2.8	Сургалтын зардал	-	-
5.2.9	Бусад	-	-
5.3	<b>Бусад зардал (5.3.1+...+5.3.26)</b>	<b>11,781,077</b>	<b>8,104,572</b>
5.3.1	Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	-	-
5.3.2	Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	42,276	45,638
5.3.3	Санхүүгийн түрээс болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	-	-
5.3.4	Факторинг болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	-	-
5.3.5	Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан зардал	4,611,377	4,126,987
5.3.6	Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	5,033,396	2,650,936
5.3.7	Даатгал	39,490	22,796
5.3.8	Түрээс	1,080	7,499
5.3.9	Ашиглалтын зардал /цахилгаан, уур ус, дулаан, цэвэр, бохир ус/	11,693	6,035
5.3.10	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	709,065	465,718
5.3.11	Харуул, хамгаалалтын зардал	-	-
5.3.12	Харилцаа холбоо, интернет	479,607	261,267
5.3.13	Шатахуун болон тээврийн зардал	13,791	6,030
5.3.14	Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	25,644	45,649
5.3.15	Зохицуулалтын хураамжийн зардал	14,271	5,166
5.3.16	Хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах зардал	-	-
5.3.17	Захиалгат хэвлэлийн зардал	-	-
5.3.18	Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	419	40
5.3.19	Ногдол ашиг	-	-

5.3.20	Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	482,738	202,297
5.3.21	Бичиг хэргийн зардал	38,810	13,823
5.3.22	Ариун цэврийн зардал	16,216	7,295
5.3.23	Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	-
5.3.24	Харилцагчдын сургалт судалгааны зардал	3,909	3,834
5.3.25	Бусад	257,295	233,562
6	<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН (4-5)</b>	- 4,305,748 -	5,186,131
7	<b>БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАХААС ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ (3+6)</b>	28,320,110	24,156,740
8	<b>БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ</b>	2,684,956	1,398,990
8.1	Үнэт цаасны эрсдэлийн зардал	-	-
8.2	Зээлийн эрсдэлийн зардал	1,953,337	307,216
8.3	Санхүүгийн түрээсийн эрсдлийн зардал	-	-
8.4	Факторингийн үйлчилгээний эрсдэлийн зардал	-	-
8.5	Найдваргүй авлагын нөөцийн зардал	731,619	1,081,194
8.6	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал	-	10,580
9	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ (7-8)</b>	25,635,153	22,757,751
10	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	146,442	157,273
10.1	Алданги	-	-
10.2	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
10.3	Ногдол ашгийн орлого	-	-
10.4	Хандив	-	-
10.5	Тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөгдөлт	146,299	154,443
10.6	Бусад	143	2,829
11	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	410,872	288,233
11.1	Зочин төлөөлөгчийн зардал	3,949	36,885
11.2	Торгуулийн зардал	64,615	-
11.3	Хөрөнгө данснаас хассаны гарз	-	-
11.4	Баяр ёслол	-	-
11.5	Бусад	208,289	251,348
12	<b>ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ (9+10-11)</b>	25,370,723	22,626,791
13	Ердийн бус орлого	-	-
14	Ердийн бус зардал	-	-
15	<b>ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ (12+13-14)</b>	25,370,723	22,626,791
16	<b>ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ</b>	5,574,907	5,516,460
17	<b>ЦЭВЭР АШИГ (15-16)</b>	19,795,816	17,110,331



Байгууллагын нэр: ЛЭНДМН

Регистр: 5039754

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	2,084,136	10,990,758
1.1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	758,642,447	573,799,163
1.1.1	Зээлийн хүүгийн орлого	16,263,835	755,450
1.1.2	Үнэт цаасны хүүгийн орлого	-	-
1.1.3	Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого	-	-
1.1.4	Харилцах дансны хүүгийн орлого	15,231	5,893
1.1.5	Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	10,875	449
1.1.6	Санхүүгийн түрээсийн орлого	-	-
1.1.7	Гадаад валютын арилжааны орлого	-	-
1.1.8	Үнэт цаасны арилжааны орлого	9,000,000	12,189,902
1.1.9	Гадаад валютын ханшийн зөрүү	3,470	- 22,661
1.1.10	Үнэт цаасны үнэлгээний зөрүү	-	-
1.1.11	Итгэлцлийн үйлчилгээний орлого	35,542,790	38,379,849
1.1.12	Мөнгөн гуйвуулгын орлого	10,046,947	4,743,970
1.1.13	Картын үйлчилгээний орлого	-	-
1.1.14	Санхүүгийн зөвөлгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	-	-
1.1.15	Санхүүгийн түрээсийн орлого	-	-
1.1.16	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	5,500,508	-4,852
1.1.17	Хүүгийн орлогын буцаалт	- 335	-
1.1.18	Бусад үйлчилгээний орлого	682,259,125	517,751,163
1.2	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	756,558,311	562,808,405
1.2.1	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	882,990	660,755
1.2.2	Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал	-	0
1.2.3	Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө	2,649,450	1,229,653
1.2.4	Хүүгийн зардлын буцаалт	64,227	161,194
1.2.5	Үндсэн ба нэмэгдэл цалин	125,861	959
1.2.6	Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	9,585	3,450
1.2.7	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	630,976	429,457
1.2.8	Албан томилолт, сургалтын зардал	-	27,333
1.2.9	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	560	4,521
1.2.10	Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	11,693	174,902
1.2.11	Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	303,501	17,593
1.2.12	Татвар, даатгалын төлсөн мөнгө	158,394	5,269,718
1.2.13	Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	3,632,532	197,309
1.2.14	Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуудахтай холбоотой гарсан мөнгө	377,287	

1.2.15	Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	7,662,400	3,268,763
1.2.16	Факторинг болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	-	0
1.2.17	Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	314,470	200,824
1.2.18	Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарах мөнгө	19,916,647	22,756,461
1.2.19	Аудитын төлбөр, мэргэжлийн зөвөлгөө үйлчилгээний мөнгө	623,707	413,170
1.2.20	Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	14,271	5,165
1.2.21	Ногдол ашгаар олгосон мөнгө	1,224,653	5,453,051
1.2.22	Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	18,765,403	30,050,161
1.2.23	Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	699,189,705	492,483,967
2	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	- 90,424	58,653
2.1	<b>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	90,687	121,212
2.1.1	Үндсэн ба хөрөнгө борлуулсаны орлого	-	
2.1.2	Ногдол ашгийн орлого	-	
2.1.3	Хандив	-	
2.1.4	Бусад	90,687	121,212
2.2	<b>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	181,110	62,559
2.2.1	Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	156,352	56,340
2.2.2	Торгуулийн зардал	15,000	0
2.2.3	Бусад	9,758	6,219
3	<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	1,993,712	11,049,411
4.1	<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>5,892,255</b>	<b>7,885,968</b>
4.2	<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>7,885,968</b>	<b>18,935,379</b>



Байгууллагын нэр: ЛЭНДМН  
Регистр: 5039754

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	Indicators	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний сан	Гадаад валютын хөрвүүлэх нөөц	Хуримтлагдсан ашиг
10	<b>2022 оны 12-р сарын 31 ний үлдэгдэл</b>	8,000,000.0	-2,337,547.0	2,756,859.0	57,348.2	15,753,241.0
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	0.0	0.0	0.0	0.0	0.0
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/ бууралт	0.0	0.0	0.0	0.0	0.0
4	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/ бууралт	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз	0.0	0.0	0.0	0.0	0.0
7	Тайлант үеийн цэвэр ашиг	0.0	0.0	0.0	0.0	19,795,816.0
8	Хуваарилагдсан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	-1,293,778.0
9	Хувьцаат капиталын өсөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
10	<b>2023 оны 12-р сарын 31 ний үлдэгдэл</b>	8,000,000.0	-2,337,547.0	2,756,859.0	57,348.2	34,255,279.0
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>					
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/ бууралт					
4	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/ бууралт					
5	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз					
7	Тайлант үеийн цэвэр ашиг					17,110,330.6
8	Хуваарилагдсан ногдол ашиг					-5,914,413.5
9	Хувьцаат капиталын өсөлт					
10	<b>2024 оны 6-р сарын 30 ны үлдэгдэл</b>	8,000,000.0	-2,337,547.0	2,756,859.0	57,348.2	45,451,196.1



Захирал *Ц.Ууганбаяр* /Ц.Ууганбаяр/

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ  
АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ**

2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр

№ АХ-24/03

Улаанбаатар хот

**Дүгнэлт гаргах тухай**

**Хуралдсан газар, хугацаа:** 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр эчнээ санал хураалт явуулав.

**Хуралд оролцсон:** Хорооны дарга Ж.Жаргалсүрэн, гишүүн С.Боргил, Ц.Одмаа нар тус тус биечлэн оролцов.

**Хурлын ирц:** 100 хувь

**Хэлэлцсэн асуудал:** 2024 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.1 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот Үнэт цаасны бүртгэлийн журмын холбогдох хэсгийг тус тус үндэслэн “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн дэргэдэх Аудитын хорооноос **ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:**

1. Компанийн зүгээс 2024 оны эхний хагас жилийн байдлаарх санхүү, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тоон үзүүлэлтүүдийг бэлтгэж ирүүлсэнтэй ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо танилцсан болохыг тэмдэглэсүгэй.
2. Компанийн 2024 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн санхүүгийн үзүүлэлт, мэдээллүүд нь бодитой тусгагдсан болохыг баталгаажуулсугай.
3. 2024 оны эхний хагас жилийн тайлан болон шаардлагатай бусад мэдээллийг холбогдох журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх, олон нийтэд тайлагнан ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



**ХОРООНЫ ДАРГА:**

Ж.ЖАРГАЛСҮРЭН

**ГИШҮҮД:**

С.БОРГИЛ

Ц.ОДМАА